

ЭРҮҮЛ МЭНДИЙН ШИНЖЛЭХ УХААНЫ ИХ СУРГУУЛЬ
НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН СУРГУУЛЬ

Эрдэнэбатын Батсайхан

Дипломын ажил

“Хайрст үлд өвчнийг эмчлүүлж буй хүмүүсийн сэтгэл түгшилтийн
байдал”

Улаанбаатар

2013 он

Дипломын ажлыг ЭМШУИС-ийн Нийгмийн Эрүүл Мэндийн сургууль, Нийгэм-Хүмүүнлэгийн ухааны тэнхмийг түшиглэн хийж гүйцэтгэв.

Дипломын ажлын удирдагч багш.....Ц.Эрдэнэсамбуу

(Анагаах ухааны доктор, профессор)

Дипломын ажлын шүүмжлэгч багш.....Н.Мэнтэвдорж

(Анагаах ухааны доктор)

Агуулга

Нэгдүгээр бүлэг : Удиртгал	4
1.1 Судалгааны ажлын үндэслэл	4
1.2 Судалгааны ажлын зорилго, зорилт	5
1.3 Судалгааны ажлын таамаглал	5
1.4 Судалгааны шинэлэг тал	5
1.5 Судалгааны ажлын практик ач холбогдол	5
1.6 Судалгааны ажлыг хэлэлцүүлсэн байдал	6
1.7 Судалгааны ажлын багтаамж	6
1.8 Нэр томъёоны тайлбар	6
Хоёрдугаар бүлэг : Хэвлэлийн тойм	7
2.1 Хайрст үлд	7
2.2 Сэтгэл түгшилт	8
2.3 Өвчин туссан хүний сэтгэл зүй	14
2.4 Арьсны өвчин туссан хүний сэтгэл зүй	18
2.5 Судлагдсан байдал	18
Гуравдугаар бүлэг : Судалгааны арга, аргачлал	18
3.1 Судалгааны хамрах хүрээ	19
3.2 Судалгааны арга	19
3.3 Үр дүнгийн боловсруулалт	19
Дөрөвдүгээр бүлэг : Судалгааны ажлын үр дүн	20
4.1 Сэтгэл түгшилтийг түвшинг тодорхойлсон үр дүн	22
4.2 Сэтгэл хөдлөлийн байдлыг тодорхойлсон үр дүн	24
4.3 Анх болон давтан эмчлүүлж буй хүмүүсийн сэтгэл түгшилтийг харьцуулсан үр дүн	25
Тавдугаар бүлэг : Хэлцэмж	28
Зургадугаар бүлэг : Судалгааны ажлын дүгнэлт ба зөвлөмж	29
Ном зүй	31
Хавсралт	33

Нэгдүгээр бүлэг : Удиртгал

1.1 Судалгааны ажлын үндэслэл

Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллага (ДЭМБ) –ын мэдээллийн материалаас авч үзэхэд арьсны өвчнөөр өвчилж байгаа дэлхийн хүн амын 2,5-5 хувийг псориоз буюу хайрст үлд өвчин эзэлж байна.¹АНУ-д хүн амын 1,4-4,6% , Төв Европд ойролцоогоор 1,5% , харин манай оронд хүн амын 5,2% нь хайрст үлд өвчинтэй гэсэн судалгаа байдаг.²

Хайрст үлд өвчин нь бусад эрхтэн системийн өвчнүүдийн нэгэн адил өвчтөний ажил хөдөлмөрийн түвшин болон амьдралын чанарыг бууруулдаг архаг өвчин юм.³

Монгол улсын хүн амын өвчлөлийн 2002-2008 оны улсын статистик тайлангийн материалаас, арьс халимын өвчний ангилал нь улсын хэмжээнд нийт өвчлөл дотор өвчлөлийн тоогоор (4,5%) 8-р байранд, аймгийн дунджаар (4,07%) 7-р байранд байна.Арьсны нийт өвчлөлийн 34,26%-ийг хайрст үлд өвчин эзэлж хоёрдугаар байранд орж байна.⁴

Хайрст үлд нь тархалт ихтэй, арьсны архаг өвчин бөгөөд энэ өвчний үед арьс төдийгүй хумс, үе мөч, мөн сүүлийн үед бөөр зэрэг дотор эрхтнүүд гэмтдэг гэж зарим судлаачид үзэж байна. Хайрст үлд өвчний үед барагцаалбал 30-40 орчим хувьд нь сэтгэл санааны таагүй байдал, хямрал үүсч, өвчнийг сэдрээх, дордуулах нөлөөг үзүүлдэг байна.⁵

Мөн арьсны өвчнөөр өвчлөгсдийн 3 хүний 1 нь сэтгэцийн ямар нэгэн асуудалтай байдаг бөгөөд АНУ-ын Вашингтоны арьсны эмч нарын нийгэмлэгээс явуулсан судалгаагаар хайрст үлд нь зарим арьсны өвчнийг бодвол илүү сэтгэцийн эмгэг илрэлтэйг тогтоожээ.⁶

Иймд хайрст үлд өвчнөөр эмчлүүлэгчийн сэтгэл санааны байдал, сэтгэл түгшилтийг судлах шаардлага нь энэхүү сэдвийг сонгон авч судалгаа явуулах үндэслэл болж байна.

1.2 Судалгааны ажлын зорилго, зорилт

Зорилго

Хайрст үлд өвчнийг эмчлүүлэгчийн сэтгэл түгшилтийн түвшинг судлахад судалгааны ажлын зорилго оршино.

Зорилт

Энэхүү зорилгодоо хүрэхийн тулд дараах зорилтуудыг дэвшүүлэн судалгааг явуулна. Үүнд:

1. АӨСҮТ-д хайрс үлд өвчнөөр хэвтэн эмчлүүлж буй судалгаанд оролцогчдын нөхцөл байдлын түгшилтийн (одоогийн сэтгэл түгшилт) түвшинг тодорхойлох
2. Судалгаанд оролцогчдын хувь хүний сэтгэл хөдлөлийн байдлыг тодорхойлох
3. Анх удаа болон хоёр ба түүнээс дээш удаа хэвтэн эмчлүүлж буй эмчлүүлэгчдийн сэтгэл түгшилтийн байдлыг харьцуулан судлах

1.3 Судалгааны ажлын таамаглал

Хайрст үлд өвчнийг анх удаа хэвтэн эмчлүүлж буй эмчлүүлэгч нь хоёр ба түүнээс дээш удаа хэвтэн эмчлүүлж буй эмчлүүлэгчдийг бодвол илүү их сэтгэл түгшилтэнд ордог байж болзошгүй.

1.4 Судалгааны ажлын шинэлэг тал

Хайрст үлд өвчний үед Ханин-Спилбергерийн сэтгэл түгшилтийн сорилыг анх удаа хэрэглэж байгаа нь судалгааны ажлын шинэлэг тал нь болж байна.

1.5 Судалгааны ажлын практик ач холбогдол

- Хайрст үлд өвчнийг эмчлүүлж буй хүмүүсийн сэтгэл түгшилтийн байдлыг танин мэдсэнээрээ энэ чиглэлээр төрөл бүрийн үйл ажиллагаа төлөвлөн хэрэгжүүлэх боломжтой болох бөгөөд цаашид энэ чиглэлээр судалгаа, шинжилгээ хийж буй хүмүүст мэдээллийн эх сурвалж болох ач холбогдолтой.

- Энэ өвчний талаар эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийн ажлын арга барилд тодорхой хэмжээгээр мэдлэг, мэдээлэл болон ашиглагдах боломжтой юм.

1.6 Судалгааны ажлыг хэлэлцүүлсэн байдал

- ЭМШУИС-НЭМС-ийн Нийгэм-Хүмүүнлэгийн ухааны тэнхимийн 2012 оны 10-р сарын 2-ны өдрийн хурлаар дипломын ажлын сэдэв, арга аргачлалыг баталсан.
- ЭМШУИС-ийн Анагаахын ёс зүйн хяналтын хорооны 2012.11.02-ны өдрийн хурлаар \№1211-З\1А\ хэлэлцүүлэн, ёс зүйн зөвшөөрлийн дагуу судалгааг явуулсан.
- ЭМШУИС-НЭМС-ийн Нийгэм-Хүмүүнлэгийн ухааны тэнхмийн 2013 оны 04-р сарын 25-ны өдрийн хурлаар \№13\09\ дипломын урьдчилсан хамгаалалтанд орсон.
- ЭМШУИС-ийн Анагаахын ёс зүйн хяналтын хорооны 2013.05.02-ны өдрийн хурлаар ёс зүйн ямар нэгэн зөрчилгүй гэж дүгнэсэн.

1.7 Судалгааны ажлын багтаамж

Судалгааны ажлыг аrial 12 , мөр хоорондын зай нь 1,5 , зүүн талаасаа 2,5 , баруун талаас 0,5 , дээр доороос 2,0 мм хэмжээтэйгээр хийсэн. Судалгааны ажил нийт 36 хуудаснаас бүрдэх бөгөөд үүнд хүснэгт 2, зураг 12 орсон болно.

1.8 Нэр томъёоны тайлбар

- ❖ Хайрст үлд : Архаг явцтай, тархалт ихтэй, дахилт өгдөг, халдваргүй арьсны өвчин.
- ❖ Сэтгэл түгшилт :Сэтгэл түгшилт нь аюулын дохиог хүлээн авсан үед үүсдэг сэтгэцийн хариу урвал юм. Сэтгэл түгшилт нь сэтгэц, физиологийн нэгдэл бүхий бие, ааш араншин, сэтгэл хөдлөлийн өвөрмөц хариу урвалаар илэрдэг. Сэтгэл түгшилтийг гарал үүслээр нь анхдагч, хоёрдогч гэж ангилдаг.

- ❖ Хувь хүний сэтгэл хөдлөл : Уг хүний “Би”-д аюул заналхийлэл учруулж байгаа үед сөрөг сэтгэл хөдлөлөөр хариу үйлдэл үзүүлэх хандлагыг тодорхойлж байгаа хувь хүний сэтгэл зүйн төрөлхийн хувийн онцлог шинжийг хэлнэ. Товчоор хувь хүний сэтгэл хөдлөл нь тухайн хүний хувийн онцлогтой холбоотой. Өөрөөр хэлбэл энэ нь тухайн хүний төрөлхийн анхдагч сэтгэл хөдлөл юм.
- ❖ Нөхцөл байдлын түгшүүр : Түр зуурын шинжтэй ямар нэгэн шалтгааны улмаас үүсч буй түгшүүрийг хэлнэ. Товчхондоо энэ нь стресээс үүдсэн түгшилтийг хэлэх бөгөөд энэ нь хоёрдогч сэтгэл хөдлөл юм.

Ном зүй :

1. АӨСҮТ, “Арьсны эмч нарын бүтээл” , Улаанбаатар, 1996 он, “Псириоз” \х.64-87\
2. АӨСҮТ, МАӨЭНН, ЭМШУИС, “Арьс судлал” сэтгүүл, Улаанбаатар 2010 он , “Хайрст үлд өвчний эмнэл зүйг эсийн дархлаатай холбон судалсан нь” \х.23-26\
3. ЭМЯ, ДЭМБ, “Анагаах ухааны эрдмийн бүтээлийн товчоон” , Улаанбаатар, 2003 он, \195-197\
4. Дүүмаам.И , “Арьсны өвчний эмчилгээний эмийн хэрэглээнд хийсэн маркетингийн судалгаа” 2010 он
5. Хандсүрэн.Б , “Арьсны өвчин” , Улаанбаатар , 2010 он /х.214-222 /
6. АӨСҮТ, МАӨЭНН, ЭМШУИС, “Арьс судлал” сэтгүүл, Улаанбаатар 2010 он , “Арьсны зарим өвчний үед сэтгэл заслын эмчилгээ хийсэн судалгааны үр дүн” \х.62-65\
7. ЭМЯ, ДЭМБ, “Анагаах ухааны эрдмийн бүтээлийн товчоон” , Улаанбаатар, 2003 он, \195-197\
8. Хандсүрэн.Б , “Арьсны өвчин” , Улаанбаатар , 2010 он /х.214-222 /
9. Эрдэнэсан.Ч , “Арьс өнгөний өвчний сурах бичиг” , Улаанбаатар, 1981 он, “Хайрст үлд” \х.122-128\
10. Thomas.P.Habif , “Clinical dermatology” ,Chapter 8, Psoriasis and other papulosquamous diseases p.264-266
11. Хандсүрэн.Б , “Арьсны өвчин” , Улаанбаатар , 2010 он /х.214-222 /
12. Мөнхбаяр.С , “Батга өвчинд өгөх сэтгэл түгшилтийн хариу урвал” Анагаах ухааны магистрын зэрэг горилсон бүтээл, 2010 он
13. Оргил.Б . “Өрхийн анагаах ухаан” , Улаанбаатар, 2005 он \х.22-28\
14. Бямбасүрэн.С , “Сэтгэцийн эмгэг судлал” , Улаанбаатар , 2007 он, \Х.359-364\
15. Мягмар.О , “Сэтгэц заслын зөвлөгөөний арга зүй” , Улаанбаатар, 2010 он, \х.276-281, 321-324,\
16. Мөнхбаяр.С , “Батга өвчинд өгөх сэтгэл түгшилтийн хариу урвал” Анагаах ухааны магистрын зэрэг горилсон бүтээл, 2010 он , Мягмар.О , “Сэтгэц заслын зөвлөгөөний арга зүй” , Улаанбаатар, 2010 он, \х.276-281, 321-324,\
17. Энхбаяр.Э, Жавзан.Б , “Боловсорлын сэтгэл судлал” , Улаанбаатар , 2009 он \х.83-87\

18. Мягмар.О , “Сэтгэц заслын зөвлөгөөний арга зүй” , Улаанбаатар, 2010 он,
\х.276-281, 321-324,\
19. Энхбаяр.Э, Жавзан.Б , “Боловсорлын сэтгэл судлал” , Улаанбаатар , 2009 он
\х.83-87\
20. Мягмар.О , “Сэтгэц заслын зөвлөгөөний арга зүй” , Улаанбаатар, 2010 он,
\х.276-281, 321-324,\
21. Монгол улсын ЭМЯ, Азийн хөгжлийн банк , “Нийгмийн эрүүл мэнд” ,
Улаанбаатар хот, 2007 он
22. Бямбасүрэн.С , “Сэтгэцийн эмгэг судлал” , Улаанбаатар , 2007 он, \Х.359-364\
23. Мөнхбаяр.С , “Батга өвчинд өгөх сэтгэл түгшилтийн хариу урвал” Анагаах
ухааны магистрын зэрэг горилсон бүтээл, 2010 он